



**Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс
авсан 2024 оны 08 дугаар сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл**

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ


- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:




Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 68 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 31 иргэн буюу 45.6% эмэгтэй, 37 иргэн буюу 54.4% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.

График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны иргэн буюу 4.4%, 30-39 насны 42 иргэн буюу 61.8%, 40-49 насны 16 иргэн буюу 23.5%, 50-59 насны 7 иргэн буюу 10.3% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

График2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон 68 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 6 иргэн буюу 8.8%, тэтгэмж 15 иргэн буюу 22.1%, сайн дурын даатгал 23 иргэн буюу 33.8%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 3 иргэн буюу 4.4%, зөвлөгөө мэдээлэл 11 иргэн буюу 16.2% тус бүр авсан байна.

Хүснэгт1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн 12 даатгуулагч маш сайн үнэлгээг өгсөн (17.6%), сайн үнэлгээг 55 даатгуулагч буюу (80.9%), дунд үнэлгээг 1 даатгуулагч (1.5%), муу, маш муу үнэлгээг өгөөгүй байна.

Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 68 иргэн буюу 100% үнэлгээ өгсөн байна.

Зураг 3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:




Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 68 иргэн буюу (97.1%) сэтгэл дундуур 2 иргэн (2.9%) тус бүр өгсөн байна.

Зураг4:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа\:

Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал\Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа\:	Иргэдийн тоо	Хувь хэмжээ
Тийм	15	22.1%
Үгүй	52	76.5%
Мэдэхгүй	1	1.5%
Нийт тоо:	68	100%

Дүгнэлт: Судалгаанд оролцсон 68 иргэдийн “Тийм” үнэлгээг 15 иргэн буюу (22.1%),”Үгүй” үнэлгээг 52 иргэн буюу (76.5%), Мэдэхгүй үнэлгээг 1 иргэн буюу (1.5%) тус бүр үнэлсэн байна.

График4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 68 иргэдийн “Тийм” үнэлгээг 13 иргэн буюу (19.1%), “Үгүй” үнэлгээг 55 иргэн буюу (80.9%) тус бүр үнэлсэн байна.

График5: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 68 иргэнээс “Тийм” үнэлгээг 55 иргэн буюу (81%), “Үгүй” үнэлгээг 13 иргэн буюу (19.1%) үнэлсэн байна.

Судалгааны нэгтгэл хийсэн:/Н.Шүрэн-Эрдэнэ/